



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ НАРЫН
2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024 оны 04 дүгээр сарын 02

Дугаар 2024/17

Номгон

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрээний зорилго нь Баянхонгор аймгийн Засаг даргаас Шинэжинст сумын Засаг даргын хооронд үүсэх эрх, үүрэг, гүйцэтгэх ажил үйлчилгээ, түүний тоон болон чанарын үзүүлэлт, хүрэх үр дүн, төсвийн санхүүжилтийг тодорхойлох, гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тавигдах шаардлага, гэрээг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төсвийн тухай хуулийн 40 дүгээр заалтыг үндэслэн энэхүү гэрээг нэг талаас Баянхонгор аймгийн Засаг дарга Долгорсүрэнгийн Мөнхсайхан, нөгөө талаас Шинэжинст сумын Засаг дарга Базарсадын Бат-Эрдэнэ нар 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нэг жилийн хугацаатайгаар байгуулж 2 хувь үйлдэв.

1.3.Уг гэрээнд аймгийн Засаг даргаас төлөөлөн гүйцэтгэх, сумын Засаг даргын чиг үүрэг, ажил үйлчилгээг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүргэж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ түүний зардлын санхүүжилт, талуудын хүлээх үүрэг, гэрээний биелэлтийг тайлагнах, дүгнэх зэрэг гэрээний нөхцөлийг тусгав.

1.4.Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хооронд байгуулсан гэрээтэй холбогдох харилцааг төрийн албаны тухай хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад салбарын үйл ажиллагааг зохицуулах болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.5.Хавсралт энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг

2.1.Төсвийн ерөнхийлөн захирагч болох аймгийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ.

2.2.Тухайн сумд гүйцэтгэх ажлыг худалдаж авахад 598,182.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн санд 2.907.637.2 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгоно. /Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэгчийг шалгаруулах тендерээр авсан үнийн дүнгийн хэмжээгээр санхүүжилт олгоно./

2.3.Гэрээний нөхцөл болон ажил үйлчилгээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулах, дэмжлэг үзүүлэх, арга хэмжээг авч, харилцан уялдаатай ажиллах.

2.4.Сумын Засаг даргаас гүйцэтгэх үйл ажиллагааны үр дүнгийн талаарх эцсийн хариуцлагыг аймгийн Засаг дарга ажлаа тайлагнадаг дээд шатны байгууллага болох Засгийн газрын өмнө хариуцна.

2.5.Санхүүжилтийн хуваарьт шаардлагатай тохиолдолд сар улирлаар зохицуулалт хийж болно.

Гурав. Сумын Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Сумын Засаг дарга нь гэрээнд тусгагдсан 142 арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаж, заалт бүрийг зорилтот түвшинд хүргэж хэрэгжүүлэхэд анхаарч, зохион байгуулалтыг шуурхай удирдлагаар хангаж, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тайлагнаж, аймгийн Засаг даргын өмнө хариуцах.

3.2.Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж, орлогыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг татаж, төсвийн сахилга батыг хянаж, зөрчилгүй ажилласан байх.

3.3.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын байрны дэг журам, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, ашиг сонирхол, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх.

3.4.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшнийг бууруулж, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах.

3.5.Аймаг орон нутагт хэрэгжиж байгаа дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлж, салбарын удирдлагуудтай нягт уялдаа холбоотой хамтран ажиллах.

3.6.Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх, төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэж ажиллах

3.7.Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам шинэчлэн батлах тухай” журмын хэрэгжилт, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай зохион байгуулж, хяналт шинжилгээ үнэлгээний дүнг өмнөх оноос ахиулсан байх

3.8.Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж

ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;

Дөрөв. Улсын төсвийн санхүүжилт

4.1.Сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилт нь төсөв батлах тухай, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан тухайн оны төсөв байх бөгөөд түүний санхүүжилтийг хуваарийн дагуу төрийн сангаар дамжуулан гүйцэтгэх.

4.2.Сумын төрийн сан төсөвт байгууллагын санхүүжилтийг төсвийн дансанд ажлын нэг хоногт багтаан шилжүүлэх.

4.3.Аймгийн Засаг даргын нэрийн өмнөөс сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилтийн төлбөрийг аймгийн Засаг даргатай тохиролцсон хуваарийн дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст шилжүүлнэ. Энэ тохиолдолд 4.2, 4.3 дахь заалт нэгэн адил хүчинтэй тооцох.

4.4.Төсвийн тухай хуулийн 41.1, 41.2 дугаар зүйлд заасны дагуу сумын Засаг даргаас эрхлэн гаргасан сар бүрийн санхүүгийн тайлан, улирал бүрийн эцэст төсвийн хуваарилалт, зарцуулалт, бүрдүүлэлтэд хяналт тавьж тайлан гаргаж аймгийн Засаг даргад хүргүүлэх.

4.5.Сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол аймгийн Засаг дарга түүний төлбөрийг хийх үүрэг хүлээхгүй. Ирүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний тайланд хийсэн үнэлгээгээр гэрээнд хийсэн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаагүй бол дараагийн улирал, жилийн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний төлбөрийг зохих журмын дагуу бууруулан зохицуулалт хийх.

4.6.Сумын санхүүгийн албаны дарга төрийн сангийн мэргэжилтэн болон төсвийн нягтлан бодогчдыг томилж чөлөөлөхдөө аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй зөвшилцөж Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөх.

4.7.Улс аймаг, сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, улс аймгийн төсвийн орлогод төвлөрүүлэх орлогыг цаг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх.

4.8.Сумын Засаг дарга нь төсөв болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлэх.

Тав.Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээг дүгнэх

5.1.Гэрээний биелэлтийг хавсралтад заасан хэрэгжүүлэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түшингийн үр дүнг журмын дагуу хэрэгжилтийг хагас жилээр 2024 оны 06 дугаар сарын 15-нд , жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 15-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаа хоцроолгүй тайлагнана.

5.2.Хамтран ажиллах гэрээг Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлага хангаж, дээд газрын буюу Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн үнэлгээгээр хэрэгжилтийн товчоо үйлдэж, холбогдох эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг дарж, баталгаажуулж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тухайн оны дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор цаасаар ирүүлнэ.

5.3.Сумын Засаг даргын хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний тайланд дүгнэлт хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.4.Шаардлагатай бол тусгайлсан мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэнэ.

Зургаа . Гэрээгээр харилцан хүлээх үүрэг

6.1.Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2.Төрийн албаны тухай, Төсвийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн заалтуудыг баримтлан ажиллана.

6.3.Гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж, хугацаа хожимдуулах тасалдуулах зэрэг алдаа дутагдал гаргахгүй ажиллана.

6.4.Шаардлага гарсан нөхцөлд харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээг цуцалж болно.

Долоо.Маргааныг шийдвэрлэх

7.1.Гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох үүссэн маргааныг шийдвэрлэхдээ:

7.2.Хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээтэй холбогдон үүссэн асуудлыг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэж байна.

7.3.Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зохицуулах арга хэмжээ авхуулна.

7.4.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зөвлөгөө авч ажиллана.

Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

8.1.Гэрээ байгуулснаас хойш эхний зургаан сард, сүүлийн зургаан сард биелэгдэхүйц нэмэлтээр ажил арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг тооцож болно.

8.2.Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.3.Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь хийж, талууд гарын үсэг зурж гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг хадгална.

8.4.Гэрээнд тусгагдаагүй чиг үүрэг, ажил үйлчилгээг талууд харилцан зөвшилцөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх болно.

Ес. Гэрээний хариуцлага

9.1.Сумын Засаг дарга гэрээний хавсралтад тусгагдсан үүргийг хангалттай биелүүлсэн тохиолдолд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага, урамшууллыг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

9.2.Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгавар, хариутай албан бичиг, мэдээ тайланг хугацаанд нь шаардлагын дагуу гаргаж ирүүлэх, биелүүлээгүй тохиолдолд Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.МӨНХСАЙХАН

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ

2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ
АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилт арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түшин	2024 онд хүрэх түвшин
1	2	3	4	5
1. Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд				
1.1	2024 онд дэвшүүлсэн зорилт арга хэмжээ /Шинэ санал санаачилга, онцлог ажил, нэрлэсэн жил/	Гүйцэтгэлийн хувь	-	95%
1.2	Хот хөдөөгийн сэргэлт хүрээнд "Нээлттэй аймаг" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Шилжин ирсэн иргэдийн тоо	-	Суманд шилжин ирсэн иргэдийн тоон мэдээлэл
		Шилжин явсан иргэдийн тоо	-	Сумаас шилжин явсан иргэдийн тоон мэдээлэл
1.3	Цаг үеийн байдлаар Засгийн газрын болон аймаг орон нутгаас өгч байгаа шуурхай үүрэг даалгаврыг нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллах	Хяналтад авсан хууль тогтоомжийн тоо Хэрэгжилтийн хувь	- -	25 90%
1.4	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу үр дүнтэй тайлагнах	Тайлангийн ирц тайлангийн чанар БББ, ХТТШ-ийн хэрэгжилтийн хувь	75 30% 10%	95 60% 50%
1.5	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн тоо	1	1
		Төлөвлөгөөний биелэлтийн хувь	50%	70%
		Нийт албан хаагчдын 30-ээс дээш хувийг сургалтад хамруулах	10%	30%
1.6	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн талаар сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх	Ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдсон албан хаагчийн тоо	-	0
		Өмнөх оноос буурсан хувь	-	0,1%-0,5%
1.7	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сумын хэмжээнд зохион байгуулж, төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтгүйгээр томилохгүй байх	Зөрчилтэй томилгооны бууралтын хувь	3%	0%
1.8	Сул орон тоог тухай бүр мэдээлж нөхөж ажиллах	Сул орон тоог нөхсөн хувь	30%	100%

1	2	3	4	5
1.9	Сумын удирдлагууд гадаад арга хэмжээнд оролцох, гаднын байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийхдээ харьяалах нутгийн захиргааны дээд шатны байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл авч, удирдамж батлуулах бөгөөд үр дүнг ажлын 7 өдрийн дотор холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, удирдамжийн дагуу дэлгэрэнгүй илтгэх хуудас, ярианы тэмдэглэлээ ирүүлнэ.	Батлуулсан удирдамж, хүргүүлсэн илтгэх хуудасны тоо	0	1
1.10	Нийтийн мэдээллийн тухай хуулийн 98 шалгуур үзүүлэлтийг сумын албан ёсны цахим хуудастаа тогтмол ил тод, нээлттэй мэдээлэх	Шинэчилсэн мэдээний тоо Бүрдлийн хувь	30 60%	70 100%
1.11	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 8.5.1, 8.5.2 зүйлд хамаарах мэдээллийг албан ёсны цахим хуудсандаа бүрэн, ил тод байршуулж, баяжилт бүрдлийг хангах	Шинэчилэн байршуулсан үйлчилгээний мэдээллийн тоо	0	6
1.12	Сумдын албан ёсны цахим хуудастаа мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх мэдээллийг тогтмол ил тод, нээлттэй мэдээлэх	Шинэчилсэн мэдээний тоо Бүрдлийн хувь	0 50%	8 90%
1.13	Irgen.bayanhongor.gov.mn иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлж, иргэдийг судалгаанд хамруулах	Судалгаанд хамруулсан иргэдийн тоо	-	150-с дээш
1.14	Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг байнга ил тод, нээлттэй мэдээлж, албан ёсны цахим хуудастаа байршуулах	Тандалтын тоо	1000	4000- дээш
2.Гамшгийн үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд				
2.1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сум орон нутгийн түвшинд чанар, үр дүнтэй зохион байгуулах	Гамшгийн үеийн мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн бэлэн байдлын хувь	70 %	80 %
2.2	Шар ус, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сум орон нутгийн түвшинд чанар, үр дүнтэй зохион байгуулах	Эрсдэлийн буурсан хувь	70 %	90 %
2.3	Гамшгаас хамгаалах "Иж бүрэн" сургуулийг Баянлиг, Хүрээмарал сумдад зохион байгуулах	Ослын үед бэлэн байдал хангалтын хувь -Иргэдийн гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтын хувь	60% 30%	90% 40%
2.4	Гамшгаас хамгаалах "Команд штаб"-ын сургуулийг Богд, Жаргалант сумдад зохион байгуулах	Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлэн байдлын хангалтын хувь	60%	90%
2.5	Гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"-ийг Баян-Өндөр, Галуут сумдад зохион байгуулах	Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлэн байдлын хангалтын хувь	60%	90%

1	2	3	4	5
2.6	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн шинэчлэн хянуулж, батлуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	95%
2.7	Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн шинэчлэн хянуулж, батлуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	95%
2.8	Өвөлжилтийн бэлтгэл хангах үйл ажиллагааг сум орон нутгийн түвшинд зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах	Бэлтгэл ажлын хангалтын хувь	70 %	90 %
3. Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:				
3.1	Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	500
		Хэлэлцүүлгийн тоо	-	200
		Сурталчилгааны тоо	-	1000-аас доошгүй гарын авлагыг иргэдэд түгээх
3.2	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх	Захиргааны хэм хэмжээний актын тоо	-	5-аас доошгүй
3.3	Иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлыг сумын хэмжээнд эрчимжүүлэх	Цахим гарын үсгийн олголтын хувь	-	100%
3.4	УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүний эрхийн үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хамаарал бүхий заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	100%
3.5	Хэрэглэгчийн эрхийн хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын тоо Сургалтын тоо	-	4 4
3.6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЦГ-тай хамтран камержуулах ажлыг зохион байгуулах	Камержуу лалтын тоо	-	1-5
3.7	Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг архины эмчилгээнд хамруулж, ажлын байраар хангах	Архинаас гарсан иргэдийн тоо	-	5
		Ажлын байраар хангасан иргэний тоо	-	3
3.8	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах	Нөлөөллийн арга хэмжээний тоо	-	3
3.9	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3
		Энэ төрлийн гэмт хэргийн бууралтын хувь	Тухайн суманд үйлдэгдсэн гэр бүлийн	0,5 хувиар бууруулах

1	2	3	4	5
			хүчирхий ллийн гэмт хэргийн тоо	
3.10	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж, малчдын бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Мал хулгайлах гэмт хэргийн гаралтын тоо	5
		Гэмт хэргийн бууралтын хувь		0,5 хувиар бууруулах
3.11	Хууль тогтоомжоор тогтоосон сумын Засаг даргын эрх хэмжээний асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, сумын Хэсгийн төлөөлөгчтэй гурвалсан гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр биелэлтийг тооцож ажиллах	Зөрчилд холбогдсон албан хаагчдын гэмт хэргийн бууралтын хувь	Нийт гэмт хэргийн тоо	0,5 хувиар бууруулах
		Гэмт хэргийн илрүүлэлт өссөн хувь	Нийт илрүүлэлтийн тоо	Нийт гэмт хэргийн илрүүлэлтийг 0,1% өсгөх
		Гэмт хэргийн бууралтын хувь	Тухайн сумын нийт гэмт хэргийн тоо	Нийт гэмт хэргийг 0,1 бууруулах
3.12	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, олон нийтийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх санаачилга гарган Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж, үр дүнд хүргэж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	100%
3.13	Цахим хуудасны ил тод байдлыг сайжруулахад анхаарч мэдээллүүдийг бүрэн байршуулж, шинэчлэн ажиллах	Ил тод байдлын үнэлгээний хувь	Тухайн сумын 2023 оны жилийн үзүүлэлт	Сумын цахим хуудасны ил тод байдлын жилийн эцсийн үнэлгээг 20-оос дээш хувиар нэмэгдүүлэх
3.14	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хуульд заасан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах	Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо	-	2
		Ашиг сонирхлын зөрчлийн тоо	-	0
		Авлигын хэмт хэрэг зөрчлийн тоо	-	0
3.15	"Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах 2023-2027 оны бодлого чиглэл"-ийг харьяа байгууллагууддаа хэрэгжүүлэх	Байгууллага -6 Нягтруулсан тавиур шүүгээний тоо,	Тухайн сумын 2023 оны жилийн эцсийн үзүүлэлт	6
3.16	"Цахим архив – Баянхонгор" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгууллагуудын	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Тухайн сумын	90%

1	2	3	4	5
	үндсэн 2021 оны болон урьд шилжүүлээгүй тасалсан бусад оны баримтыг Төрийн архивд цаасан болон цахим хэлбэрээр дансны хамт бүрэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих	Байгууллага -6	2023 оны жилийн эцсийн үзүүлэлт	
3.17	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх, 2025 оноос Төрийн албан хэргийг Монгол бичгээр явуулах бэлтгэл ажлыг хангах, 03 дугаар сарын 01-ээс эхлэн захирамж, тушаал, албан бичгийг Монгол бичгээр хослуулан хөтлөх, хэвшүүлэх	Байгууллагын тоо Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	6 90%
3.18	“Архив, албан хэрэг хөтөлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, архив бичиг хэргийн мэргэжилтэй, ажилтныг дэмжих, орон нутгийн нэмэгдэл 80 хүртэлх хувиар олгох	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь,	-	90%
		Нэмэгдэлд хамруулсан албан хаагчийн тоо	-	6
		Нэмэгдлийн хувь	-	80%
4. Боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх хүрээнд:				
4.1	Таван настнуудыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах, малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих, хяналт тавих	Хамралтын хувь	98%	100%
4.2	Орон нутагт бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжүүлэх, хяналт тавих	Хэрэгжилтийн хувь	0	60%
4.3	Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, төрийн албан хаагчдын болон иргэдийн “Монгол бичиг”-ийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх, хяналт тавих	Хэрэгжилтийн хувь	55%	80%
4.4.	Боловсролын салбарын шинээр барих болон их засвар хийх барилга байгууламжийн гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, хяналт тавих	Гүйцэтгэлийн хувь	90%	100%
4.5.	Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, тохирлын баталгаанд хамруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах	Хэрэгжилтийн хувь	50%	70%
4.6.	Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн “Өглөөний цай”, “Сүү” хөтөлбөрийг орон нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор төсөв санхүүжилтийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	Хэрэгжилтийн хувь	60%	70%

1	2	3	4	5
4.7.	Өлзийт МСҮТ-д сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, хөдөө аж ахуйн фермерийн чиглэлээр төсөгчдийг ажлын байраар хангах шинээр оюутан элсүүлэх, хамтран ажиллах	Элсэгчийн тоо	15-20	15-20
		Төгсөгчдийн тоо	20	20
		Ажлын байраар хангагдсан хувь	72%	80%
4.8.	"Суралчцагч хот" арга хэмжээ зохион байгуулж дүгнэх /Баянхонгор суманд хамраалтай/	Хэрэгжилтийн хувь	-	90%
5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн хүрээнд:				
5.1	Бүх нийтийн эрт илрүүлэг үзлэгийг орон нутагтаа чанартай зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналт тавих	Эрт илрүүлэг хамрагдалтын хувь	34.4	Хүүхдийг 80 хувиас дээш Насанд хүрэгчдийг 70 хувиас дээш
5.2	Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах, хяналт тавих	Эндэгдлийг бууруулсан хувь	Сумын үндсэн үзүүлэлт ээр	Өмнөх оноос 0.5% бууруулах
5.3	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, халдварт өвчний гаралтыг бууруулахад хяналт тавих	Халдварт өвчний тохиолдлын тоо	Сумын үндсэн үзүүлэлт ээр	Сумын үндсэн үзүүлэлтээр
		Халдварт өвчнийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%
5.4	"Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөнийг сум орон нутагтаа өрнүүлэх, архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, Монгол хүнийг өвчлөхөөс урьтаж урьдчилан сэргийлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Архи, тамхи хорт зуршлын хэрэглээнээс татгалзсан иргэдийн тоо	Сумын үндсэн үзүүлэлт тээр	Сумын үндсэн үзүүлэлтээр
		Иргэдэд чиглэсэн цогц арга хэмжээний хэрэгжилтийн хувь	80%	90%
5.5	"Жаргалтай амьдрал" төвийн сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан иргэдийг хүлээн авах, хамтран ажиллах төрийн албан хаагчийг томилох	Томилогдсон албан хаагчийн тоо	0	1
5.6	Харъяа нутаг дэвсгэрт "Өөртөө туслах бүлэг"-ийг байгуулах, үйлчлүүлэгчийг хяналтын 24 сарын хугацаанд Өөртөө туслах бүлэгт хамруулах	Хэрэгжилтийн хувь	-	90%
5.7	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дах заалтын (энэ хуулийн 6.1.3-т (малчин) заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг баг, хорооны Засаг дарга даатгуулагчтай байгуулсан гэрээний дагуу хариуцан төлүүлнэ) хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	70	90

1	2	3	4	5
5.8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо	17576	Сумын үндсэн үзүүлэлтээр
		Хамралтын хувь	90%	100%
6. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:				
6.1	Сум орон нутгийн байууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн гишүүдийг чадавхжуулах, тэднээр дамжуулан эцэг эхчүүдэд хүрч ажиллах "Шилдэг эцэг эхийн зөвлөл" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	Чадавхжуулах арга хэмжээний тоо/	1	2
		зөвлөлийн үйл ажиллагаанд хамрагдсан эцэг эхчүүдийн тоо	289	2000
		Шинээр байгуулагдсан эцэг эхийн зөвлөлийн тоо	175	10
		төрийн байгууллага /аж ахуйн нэгж/	28	20
		Уралдаанд оролцсон байгууллагын тоо	0	10
6.2	"Оны онцлох гэр бүл" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах, хамтран ажиллах	Алдаршуулсан гэр бүлийн тоо	0	9
6.3	Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, мэдээллийн санд бүртгэх, хүүхэд түүний гэр бүлд чиглэсэн үйлчилгээг төлөвлөж, эргэн хяналтыг тогтмол хийж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийн тоо	2283	2283
		Үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	5910	5980
		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	5
6.4	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар орон нутгийн хэмжээнд орон нутгийн хэмжээнд эрх зүйн акт гаргуулан биелэлтийг хангах, зөвшөөрөгдсөн хугацаанд зохион байгуулагдаж байгаа уралдааны үеэр хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хяналт тавих	Орон нутагт гаргасан эрх зүйн актын тоо/	0	1
		Хяналт тавьж ажилласан уралдааны тоо/	24	25
		уралдаанч хүүхдийн тоо/	2153	2000
		хүүхдийн бэртэл гэмтлийн хувь	8%	5%
		Цахимд системд мэдээлэл оруулсан хугацаа	14 хоног	5 хоног
6.5	"Гэр бүлийн хөгжлийг дэмжих" жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих	Хэрэгжилтийн хувь	-	100%

1	2	3	4	5
7.Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалын бодлогын хүрээнд:				
7.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, ядуу, ажилгүй иргэдийн судалгааг гарган, ядуурлын түвшинг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаар оновчтой арга хэмжээ зохион байгуулж ажиллах, өрх бүрт ажлын байр бий болгох талаар дэмжиж ажиллах	Байнгын ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	10	20
		Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	10	25
		Хүнсний эрхийн бичигт хамрагдсан өрхийн бууралтын хувь	0	10%
		Ажилгүйдэл, ядуурлын бууруултын хувь	0	10%
7.2	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах	Ахмадын өргөө, танхимын тоо	8	15
		Үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая төгрөгөөр	-	1,5 сая
7.3	"Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг хангаж, нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжид тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Ахмадын сан байгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	12%	80%
		Нийт аж ахуй нэгжийн тоо	0	20-25
		Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	3%	50%
		Нийт аж ахуй нэгж	0	10-15
